

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС,
АГЕНТЛАГ, СУМДЫН 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН
АЖЛЫН МЭДЭЭ**

2023.02.03

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар Сэлэнгэ аймагт 2023 оныг “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил” болгон зарлаж, аймгийн Засаг даргын 2023 оны А/01 дүгээр захирамжаар баталгаажууллаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2022 оны жилийн эцсийн тайланг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд хяналтад авсан нийт 44 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 129 заалтын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас татан авч нэгтгэн боловсруулсан. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт **90.08** хувийн гүйцэтгэлтэй байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2022 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллалаа. 2022 онд аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 3522 иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас 3441 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь **97.7** хувийн үзүүлэлттэй байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/527 тоот захирамжаар “Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар болон төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг үнэлэх тухай” удирдамжийн дагуу Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газраас баримтлан ажиллаж буй бодлого, шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар хяналт шалгалт хийх, ажлын явц, үр дүн, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, албан хаагчдын ажлын сахилга хариуцлага, төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдал, өвөлжилтийн бэлтгэл ажилд бодитой үнэлэлт дүгнэлт өгөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор 7 ажлын хэсэг 17 сум 6 тосгонд ажиллалаа.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2023 оны 1-р сарын 27-ны өдөр зохион байгуулж, нийт зарлагдсан 8 албан тушаалаас аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн албаны Бүртгэл санхүүгийн хэлтсийн дарга, Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоог нөхөх арга хэмжээ авлаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” 03 дугаар захирамжийн хүрээнд 1 дүгээр сарын 4-20-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллалаа.

Улсын төсвийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн тэргийг хүлээлгэн өглөө.

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын гамшгаас хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Сөүл хотын Гал,

гамшгийн удирдах газар, Ази, Африкийн хөгжлийн тусламжийн сан, УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын санаачилга, аймгийн Засаг дарга Н.Лхагвадоржтой байгуулсан “Санамж бичиг”-ийн дагуу Шаамар, Цагааннуур, Хүдэр, Түшиг сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сайн дурын албадыг гал унтраах зориулалтын 4 автомашиныг хүлээлгэн өглөө.

Аймгийн зүгээс дээрх 4 машины тээврийн зардал, гаалийн татварт нийтдээ 170 орчим сая төгрөгийг зарцуулаад байгаа бөгөөд мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэн сургаж дадлагажуулах ажил үргэлжлэн хийгдэнэ.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Гал түймэртэй тэмцэх байгууллагын 101 жилийн ойн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын ахмадын хорооноос санаачлан хийсэн “Эцэс төгсгөлгүй эхлэл” түүхэн кино Онцгой байдлын газрын цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийтэд хүргэж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд объектын гал түймрийн 18, аврах ажиллагааны 2 нийт 20 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч 2 хүний амь насыг авран хамгаалж, иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 120 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалсан байна.

Аймгийн Засаг даргын баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний удирдамжийн хүрээнд Сүхбаатар сумын 510 иргэнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч, 250 ширхэг сэрэмжлүүлэг материал тараасан.

Аймгийн Засаг даргын баталсан гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн ажилтан, алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хуваарийн дагуу Улаан загалмайн хороо, ДЗМОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөртэй хамтран 40 удаагийн 40 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж 575 алба хаагчдыг хамруулсан.

Төрийн болон төрийн бус байгууллагуудад шинэ жилийн баярын өдрүүдэд галын аюулгүй байдалд хяналт тавих үүрэг бүхий хариуцлагатай эргүүл жижүүрийг тухайн байгууллагын галын сайн дурын бүлгэмийн гишүүдээс томилж, галын аюулгүй байдлыг ханган ажиллах, баар, зоогийн газар, зочид буудал, худалдааны төв, дэлгүүрүүдийн эздэд пиротехникийн хэрэгслийг худалдан борлуулах зөвшөөрөлтэй аж нэгж байгууллагаас худалдан авч, улмаар салют буудуулах, сүлд модыг чимэглэхдээ мэргэжлийн байгууллага болон хүнээр хийлгэх талаар заавар, зөвлөмж өгч, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл 35 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад өгч ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Худалдаа, олон нийт, үзвэр үйлчилгээ, цахим тоглоомын газрын барилга байгууламжид Гамшгаас хамгаалах болон галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах” удирдамжийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 02-20-ны өдрийг хүртэл хугацаанд Сайхан суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 аж ахуй нэгж байгууллагын 4 объектод хяналт шалгалтыг явуулахад 26 зөрчлийг илрүүлэн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3 гаргаж байгууллагын дарга, эрхлэгч нарт өгч ажиллалаа.

Аж ахуй нэгж, байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу Орхон сумын Эрүүл мэндийн төв, Сайхан сумын Төмөр бетон дэрний үйлдвэр, Эрүүл мэндийн төвийн нийт 140 гаруй ажилтан алба хаагчдад “Гал түймэр”, “Газар хөдлөлтийн хавсрах

аюул, осол түүнээс урьдчилан сэргийлэх”, “Галын аюулгүй байдлаа хангах” сэдвүүдээр танхимын сургалтыг зохион байгуулж ажиллалаа.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

2023 оны 01 дүгээр сарын байдлаар улсын төсвөөс 26,1 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээнээс 5,7 сая төгрөг зарцуулж, 7,9 сая орлого бүрдүүлж, батлагдсан төсөв, төлөвлөгөө болон төсвийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж ажиллалаа.

Үйлчилгээний баталгаажуулалт: Сүхбаатар, Мандал, Алтанбулаг, Хүдэр, Шаамар сумдын 9 аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээний газрыг тохирлын үнэлгээнд хамруулж “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019 стандартын шаардлагыг хангасан 8 хүнсний дэлгүүрт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо, 1 үйлчилгээний газар нь стандартын шаардлага хангаагүй тул тохирлын гэрчилгээ олгогдоогүй байна

Экспорт баталгаажуулалт: Ерөө суманд төмрийн хүдэр олборлодог 2 аж ахуй нэгжийн төмрийн хүдэрт “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал MNS 6249 : 2011” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, 58 ширхэг экспортын тохирлын гэрчилгээ олголоо.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 9 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 6 нэрийн 10 стандартын борлуулалт хийж, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Сүхбаатар сумын худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд “Хэмжилзүйн тухай” хуулиудын хэрэгжилтийг хангуулах үүднээс ашиглагдаж буй хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулах ажлыг хийсэн.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: 2 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу ээлжит бус шалган баталгаажуулалт хийлээ. Үүнд: Цагааннуур суманд шинээр ашиглалтад орж байгаа Шатахуун түгээх газрын 3 хэмжих хэрэгслийг, Сүхбаатар сумын “Жаст” ШТС-ын дизелийн түлшний түгээгүүрийг шалган баталгаажууллаа.

Шалган тохируулгаар: 2 байгууллагын 2 лабораторийн 2 жин, 8 шилэн хэмжүүр, пипеткад шалгалт тохируулга хийлээ.

Массын хэмжлээр: Худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа 57 жин, Хөдөө, аж ахуйн дэмжих сангийн Сэлэнгэ салбар болон, Түшиг суманд үйл ажиллагаа явуулдаг “Рид хилл Монголия” ХХК-ий авто машины пүүг шалган баталгаажуулсан байна.

Дулаан даралтаар: 4 аж ахуйн нэгжийн 22 ш термометр, 2 манометр, 3 цусны даралтын аппарат шалган баталгаажууллаа.

Итгэмжлэгдсэн лабораториор: 9 аж ахуйн нэгжийн 7 нэр төрлийн 27 дээжид 83 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийснээс 1 аж ахуйн нэгжийн 1 дээж 1 үзүүлэлтээр эерэг үр дүнтэй гарсан байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

12 дугаар сард 3122 баримтаар 26,8 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн

гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

| Д/д | Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|--|--------------|--------------|-------|
| 1. Орон нутгийн төсвийн нийт орлого | | 77,215,512.8 | 87,547,787.0 | 113.4 |
| 1.1 | Орон нутгийн төсвийн орлого | 48,796,134.1 | 60,373,387.8 | 123.7 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн орлого | 20,927,550.0 | 22,971,403.8 | 109.8 |
| | Сумдын төсвийн орлого | 27,868,584.1 | 37,401,984.0 | 134.2 |
| 1.2 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг | 12,119,532.9 | 12,122,939.9 | 100.0 |
| 1.3 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/ | 10,083,679.1 | 10,083,679.1 | 100.0 |
| 1.4 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/ | 3,322,196.5 | 3,322,196.5 | 100.0 |
| 1.5 | Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/ | 170,000.0 | 170,000.0 | 100.0 |
| 1.6 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 322,671.2 | 693,212.7 | 214.8 |
| 1.7 | Сум хөгжүүлэх сангийн орлого | 2,401,299.0 | 782,371.0 | 32.6 |
| 2. Орон нутгийн төсвийн нийт зарлага | | 77,215,512.8 | 67,899,549.5 | 87.9 |
| 2.1 | Орон нутгийн төсвийн нийт зарлага | 77,215,512.8 | 67,899,549.5 | 87.9 |
| | Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага | 39,098,953.5 | 34,929,453.0 | 89.3 |
| | Сумдын орон нутгийн хөгжлийн сан | 10,517,701.5 | 8,022,105.3 | 76.3 |
| | Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага | 27,598,857.8 | 24,947,991.2 | 90.4 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт | 5,814,000.0 | 5,184,812.1 | 89.2 |
| | Аймгийн орон нутгийн хөгжлийн сан | 6,704,810.7 | 5,548,947.5 | 82.8 |
| | Халамжийн сан | 154,820.0 | 132,095.8 | 85.3 |
| | Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага | 10,189,829.9 | 9,485,487.7 | 93.1 |
| | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө | 1,585,300.0 | 1,446,550.9 | 91.2 |
| | Улсын төсөвт төвлөрүүлэх орлого | 3,150,097.2 | 3,150,097.2 | 100.0 |
| 3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг | | 19,464,478.2 | 19,464,478.3 | 100.0 |
| 3.1 | Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг | 7,344,945.3 | 7,344,945.3 | 100.0 |
| 3.2 | Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 7,095,971.6 | 7,095,971.6 | 100.0 |

| | | | | |
|------------------------------------|--|-------------|-------------|-------|
| | Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд | 141,343.2 | 141,343.2 | 100.0 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд | | | |
| | Хөрөнгө оруулалтын зардалд | 6,954,628.4 | 6,954,628.4 | 100.0 |
| 3.3 | Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 5,023,561.3 | 5,023,561.4 | - |
| | Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд | 4,604,810.7 | 4,604,810.8 | 100.0 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд | 397,100.0 | 397,100.0 | 100.0 |
| | Усан хангамжийн татаас | 21,650.6 | 21,650.6 | 100.0 |
| 4. Тусгай сангуудын зарлага | | 2,401,299.0 | 782,371.0 | 32.6 |
| 4.1 | Сумдын сум хөгжүүлэх сан | 2,401,299.0 | 782,371.0 | 32.6 |

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

| Өргөн хэрэглээний барааны нэр төрөл | | 2021-XII | 2022-XII | <u>2022-XII</u> <u>2021-XII</u> |
|-------------------------------------|--------------------------------------|----------|----------|------------------------------------|
| 1.ХҮНСНИЙ БАРАА | | | | |
| 1 | Талх, гурил, будаа | 1 500 | 2 500 | 166.6 |
| | Гурил /Алтантариа, I зэрэг, кг/ | 1 400 | 1 800 | 128.5 |
| | Талх /орон нутгийн, ш/ | 4 300 | 5 500 | 127.9 |
| | Нарийн боов /кг/ | 3 000 | 3 700 | 123.3 |
| | Будаа /кг/ | 3 000 | 3 500 | 166.6 |
| | Элсэн чихэр /кг/ | | | |
| 2 | МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | 8 500 | 9 000 | 105.8 |
| | Хонины мах /кг/ | 9 500 | 10 000 | 105.2 |
| | Үхрийн мах /кг/ | 7 500 | 8 500 | 113.3 |
| | Адууны мах /кг/ | 7 500 | 7 500 | 100.0 |
| | Ямааны мах /кг/ | 5 000 | 8 000 | 160.0 |
| | Дотор мах, цувдай /цусгүй/ | 12 500 | 17 500 | 140.0 |
| | Хиам /чанасан, кг/ | | | |
| 3 | СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | 2 200 | 2 000 | 90.9 |
| | Сүү /задгай, л/ | 3 500 | 5 500 | 157.1 |
| | Сүү / савласан, л/ | 2 500 | 3 000 | 120.0 |
| | Тараг /задгай, л/ | 22 500 | 25 000 | 111.1 |
| | Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/ | 5 000 | | |
| | Айраг /л/ | 5 500 | 7 000 | 127.2 |
| | Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/ | 450 | 500 | 111.1 |
| | Өндөг /ш/ | | | |
| 4 | Бүх төрлийн өөх тос | 7 500 | 11 500 | 153.3 |
| | Ургамлын тос /л/ | 3 000 | 4 000 | 133.3 |
| | Өөхөн тос /кг/ | 25 000 | 25 000 | 100.0 |
| | Шар тос /кг/ | 6 000 | 11 000 | 183.3 |
| | Масло /задгай, кг/ | | | |
| 5 | ХҮНСНИЙ НОГОО | 1 000 | 1 500 | 150.0 |

| | | | |
|-------------------------------------|-------|-------|-------|
| Төмс /кг/ | 2 500 | 2 500 | 100.0 |
| Лууван /кг/ | 2 500 | 2 000 | 80.0 |
| Манжин /кг/ | 2 300 | 2 500 | 108.6 |
| Байцаа /кг/ | 2 500 | 3 000 | 120.0 |
| Сонгино /кг/ | 6 000 | 7 500 | 125.0 |
| Өргөст хэмх /шилтэй, дарсан/ | 4 000 | 5 500 | 137.5 |
| Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/ | | | |
| 2. ШАТАХУУН | | | |
| Бензин А - 80 | 2 300 | 2 480 | 107.8 |
| Бензин А - 92 | 2 330 | 2 500 | 107.2 |
| Дизелийн түлш | 2 890 | 3 910 | 135.2 |

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн нэрсийн жагсаалтыг гаргаж, нийт 453 мэдүүлэг гаргагчийн судалгааг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, 88 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гарган баталгаажилтаа хийлгэсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг жил бүрийн 01 дүгээр сарын 13-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой Үндсэн хуулийн боловсрол олгох, үзэл санаа, ач холбогдлыг сурталчилан таниулах чиглэлээр сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулиар Сэлэнгэ аймгаас сонгогдсон нэр бүхий 22 депутатуудыг алдаршуулах, үйл хэргийг сурталчлах, зурган дурсамжийг нийтэд хүргэх ажлыг цахимаар зохион байгуулж, иргэд, олон нийтэд хүргэж ажиллалаа.

Уг өдрийн хүрээнд иргэдийн дунд гар бөмбөг, танин мэдэхүйн “АХА” тэмцээн хүүхэд залуучуудын дунд “Дэвжээ” тэмцээн, бага насны болон насанд хүрэгчдийн дунд Үндэсний бөхийн барилдааныг зохион байгууллаа.

Төрийн албан хаагч, иргэдэд Үндсэн хуулийн талаар мэдлэг олгох сургалт сурталчилгааг зохион байгуулж мэдээлэл өгч, гарын авлага тараан ажилласан.

Цагдаагийн газар: 2023 оны 01 дүгээр сард аймгийн хэмжээнд нийт 340 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 13 буюу 3.9 хувиар өссөн, Үүнээс гэмт хэргийн шинжтэй 87 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 47 буюу 35.0 хувиар буурсан бол Зөрчлийн 253 гомдол мэдээлэл бүртгэгдэж урд оны мөн үеэс 60 буюу 31.0 хувиар өссөн.

Нийт 79 гэмт хэрэг бүртгэгдэж, урьд оны мөн үеэс 6 буюу 7.0 хувиар буурсан бол нийт 3897 зөрчил бүртгэгдэж, урд оны мөн үеэс 1694 буюу 76.8 хувиар өссөн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр “Хяналт”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аян, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг хамруулсан сургалт, мөн аймгийн Шүүх, Прокурорын байгууллага, ахмадын зөвлөлтэй хамтарсан ажлын уулзалт, зөвлөгөөнүүдийг тус бүр 1 удаа зохион байгуулж гүйцэтгэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: “Нээлттэй хаалганы өдөрлөг”, “Эерэг харилцаа шуурхай үйлчилгээ” 7 хоногийн аяныг тус тус зохион байгуулж, 178 иргэнд мэдээлэл өгч, 278 иргэнд байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, гарын авлага тарааж, санал асуулга авч, 11 хүний ажилд орох өргөдлийг хүлээн авч, холбогдох материалыг бүрдүүлэн ажилласан.

Мөн байгууллагын ажил үйлчилгээ, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвд 4, тус газарт бичгээр 8 иргэн, ААНБ-аас талархал ирсэн.

Тайлант сард нийт 821 төлбөрийн болон хүүхдийн тэтгэлгийн материалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж, 127 материалыг дуусгавар болгож, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан 189 ялтан этгээдэд хяналт тавьж, Эрүү, Иргэн, Захиргааны шийдвэрийн тулгамдаж буй асуудлын талаар аймгийн Шүүхтэй хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулсан.

Аймгийн Шүүх шинжилгээний газар: 2023 оны 01 дүгээр сард нийт 34 гэмт хэргийн дуудлага дээр Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, мөрдөгчийн тогтоолоор 92 удаагийн шүүхийн шинжилгээ, үүнээс шүүх эмнэлгийн 69, криминалистикийн 8, тусгай шинжилгээ 15 хийж, гарын хээний дардас 154, шүүх гэрэл зураг 1155 боловсруулж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 2023 оны 01 дүгээр сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 138 /эрэгтэй-68, эмэгтэй-69, эндсэн-1/
- Гэрлэлтийн бүртгэл - 48
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 11
- Үрчлэлт - 2
- Эцэг, эх тогтоолт - 20 /үүнээс эрэгтэй10, эмэгтэй 10/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 9
- Нас баралт - 57
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 399
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 134
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 71
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 194
- Гадаад паспорт олголт - 2004
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 170
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 337 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 570
- Анхны бүртгэл - 214
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 117
- Барьцааны гэрээ - 186
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 29
- Лавлагаа хуулбар - 7
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо - 324

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 487
- Анхны бүртгэл- 41
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 99
- Барьцааны гэрээ - 305
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 13
- Лавлагаа хуулбар - 7

Архивын тасаг: Орхон, Сант, Сайхан, Сүхбаатар сумдын Засаг даргын Тамгын газар, Спортын бүрэн дунд сургуулийн захиргаанд улсын байцаагчийн шаардлага өгч, нийт 9 сум, 1 тосгоны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд шалган туслах ажлыг гүйцэтгэж, Орон нутгийн 2 үйлдвэрийн газар, 4 цэцэрлэг, 3 сургууль, 1 эрүүл мэндийн төвийн хэвлэмэл хуудсыг хянаж, Сант сумын

Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар сумын 2 дугаар сургуулиудын хэвлэмэл хуудсыг хянаж, хэвлүүлэх зөвшөөрөл олгосон.

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, төр төсвийн нийт байгууллагуудын удирдлага, бичиг хэргийн ажилтан нарт Архив бичиг хэрэг хөтлөлтийн тухай хууль, түүнийг дагалдан гарсан журам дүрмийн талаар сургалт орж, 3 агентлаг, 2 сургууль, 1 МСҮТ-ийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад арга зүйн зөвлөгөө өгсөн.

Архивын тоо бүртгэлийн нэгдсэн системд хөмрөг үүсгэгч байгууллагуудаас ирүүлсэн архивын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээг шивэх ажлыг хийж, 22 байгууллагын мэдээллийг оруулсан.

Иргэд байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу архивын хуулбар 323 магадалгаа, тодорхойлолт 20 гаргаж, 5 иргэнд онлайн магадалгаа, 2 иргэнд малын А дансны мэдээллийг тус тус гаргаж өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тушаалаар Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрыг татан буулгасантай холбоотой аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байнга хадгалах 2033-2022 оны 441 ХН, 70 жил хадгалах 2003-2022 оны 149 ХН, түр хадгалах 2010-2022 оны 1062 ХН, нийт 1653 ХН-ийг бүртгэл, актын дагуу хүлээн авч, байнга хадгалах 2003-2022 оны баримтад нягтлан шалгалтын ажлыг хийж байна.

Түнхэл тосгоны захирагчийн албаны хөмрөгийн 1965-1991 оны 188 ХН-д хэсэгчлэн тооллого, 1965-1970 оны нягтлан шалгалтыг ажлыг хийсэн. Мөн баримтын шалгалт хийгдсэн Бугант тосгоны Захирагчийн албаны хөмрөгийн 1971-1992 оны 161 ХН-ийг хайрцаглан ХН-ийн заагуур хийж хөмрөгт байршуулсан.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “Хөтөл цемент шохой” ХХК, Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн албаны хөмрөгийн 15 ХН-ийн 2177 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 1379, хүний нэр 9482, газар зүйн нэр 371, байгууллагын нэр 281 шивж эх баримттай холбох ажлыг хийсэн.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: Боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг чадавхжуулан, туршлага судлуулах, хамтран ажиллах, удирдах ажилтнуудын шинэчлэлийг хэрэгжүүлэх, төлөвлөх ур чадварыг хөгжүүлэх, Ерөө суманд баригдсан 960 хүүхдийн дэлхийн жишигт нийцсэн ерөнхий боловсролын сургууль, 200 хүүхдийн шинэ цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлуулах зорилгоор Ерөө суманд зохион байгууллаа. Сургалтад ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургалтын менежер, Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн, ажилтан нийт 103 хүн оролцлоо.

“Орон нутгийн боловсрол шинжлэх ухааны газрын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн үнэлгээ хариуцсан сургалтын менежерийг чадавхжуулах” цахим сургалтад 35 сургуулийн 37 сургалтын менежер хамрагдан боловсролын үнэлгээний талаарх үндсэн ойлголт, олон улсын үнэлгээний чиг хандлага, түүний төрөл, хэлбэр, үнэлгээний үр дүнгийн цахим тайлангийн систем, түүнийг ашиглах, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ,

сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийхэд суралцлаа.

АНУ-ын Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах алба 2016-2022 онуудад Англи хэлний ментор багшийн сургалтыг амжилттай дүүргэсэн 200 ментор багш нараас шилдэг 100 ментор багшийг шалгаруулан тэдний мэргэжлийн хөгжил, зөвлөн туслах чадварыг нэмэгдүүлэх, тэдний орон нутаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх зорилгоор “BE INSPIRED-BE THE CHANGE AGENT” уриатай “Давтан сургалт болон багш хөгжлийн төслөөр англи хэлний ментор багш нарыг чадавхжуулах сургалт”-ыг зохион байгууллаа.

БШУЯ, БСҮХ, Канадад төвтэй англи хэлний сургалт, боловсролын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Пинакл Академи”-тай хамтран 2023 онд Ерөнхий боловсролын сургуулийн 240 англи хэлний багшийг сургах масс сургалт 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс зохион байгуулагдах бөгөөд Сэлэнгэ аймгаас англи хэлний 10 багш сургалтад хамруулахаар оролцогчдын мэдээллийг хүргэн хамтран ажилласан.

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны Жайка байгууллагын санхүүжилтээр 2018-2022 онд хамтран хэрэгжүүлсэн “Суурь боловсролын чанарыг сайжруулахад Мэдээллийн Харилцааны Технологийг оновчтой ашиглах нь” төслийн үр дүнг хэлэлцэх хаалтын үйл ажиллагаа 2023 оны 01 дүгээр сарын 24-ний 09.00 цагт Боловсрол, шинжлэх ухааны яамны 401 тоот танхимд зохион байгуулагдахад 3 мэргэжилтэн оролцож, төслийг аймагтаа хэрхэн хэрэгжүүлсэн талаар танилцуулга тайлан бэлтгэж оролцлоо.

Улсын хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн 5-9-р ангиудад 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр хүртэл “PEARSON” Олон Улсын Англи хэлний сургалтын хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэхээр болсон. Тус хөтөлбөрт Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэхээр сонгогдлоо.

Монголын волейболын холбооны U13-14 насны ангиллын улсын аварга шалгаруулах тэмцээнийг Мандал суманд зохион байгуулагдаж тэмцээнд 19 аймаг 7 дүүргийн 124 багийн 1200 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Монгол Улсын Засгийн газрын 05 тоот тогтоолыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчид, иргэд, аж ахуй нэгж байгууллагын уялдаа холбоог сайжруулах, тэдгээрийг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллүүлэх, хөдөлгөөний хомсдол халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд бие бялдрыг хөгжүүлэх ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Ажлын байрандаа дасгалаа хийцгээе” тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Уг тэмцээнд 15 байгууллагын 150 гаруй аж ахуй нэгж байгууллагын төрийн албан хаагчид, иргэд хамрагдан оролцлоо.

Эрүүл мэндийн талаар: Алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд 25 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг “Халуун сэтгэл-23” нүүдлийн эрүүл мэндийн үзлэгийг Хушаат суманд суурин болон явуулын хэлбэрээр иргэдэд тусламж үйлчилгээг үзүүллээ.

Сумын эрүүл мэндийн төвд байрлах иргэдэд 5 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлж нийт 225 үзлэг, оношилгоог хийсэн байна.

Алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд явуулын 2 баг 3 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 2 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо)-г давхардсан тоогоор 339 иргэнд үзүүлэн ажиллалаа. Нийт 136

өвчлөлийг илрүүлэн, эмчилгээ зөвлөгөө өгч ажилсан ба шинээр 7 өвчлөлийг илрүүлсэн.

“Сувилагчдын бие даасан байдал- Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” уриан дор “Эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн алба”-ны хурлыг нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа Тус хурлаар 2023 онд хийх ажлын төлөвлөгөө гаргасан. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах төлөвлөгөөг батлуулах
- Ажлын байранд чадварлаг сувилагч солилцоо
- Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцлээ.

Нэгдсэн эмнэлгийн сүрьеэ, дотор, сэтгэцийн тасгийн эмч мэргэжилтнүүдтэй уулзаж чанарын хяналт хийхэд гарч буй алдаа дутагдлыг хэлж зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 47594 иргэнд 4765392.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 1 иргэнд 1200.0 мянган төгрөгийг олгоод байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүллээ. Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан EJOB программд баяжилт хийж:

- Ажил олгогчийн мэдээлэл 53
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 16 иргэн
- Идэвхтэй ажил хайгчаар 233 иргэн
- Ажил зуучлах үйлчилгээнд 25 иргэн
- Сул чөлөөтэй 128 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр 16 иргэнд үзүүлсэн байна.

2022 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 4,780,000,000 төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 49409222.12 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгөөс 58959310.15 төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 119,33 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18784 тэтгэвэр авагчдад 113980804 мянган төгрөгийг олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас 7978 даатгуулагчдад 4065625 мянган төгрөгийн ХЧТА, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгосон.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 221 даатгуулагчид 1283519 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувиллын зардалд олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 750 даатгуулагчдад 1639277 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь тус сард 3 удаа хуралдаж нийт 213 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 17 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 173 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцаллаа.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: Өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү-2023” тэмцээнийг Мандал сумын Засаг даргын Тамгын газар, Мандал сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, аймгийн Шатрын холбоотой хамтран зохион байгууллаа. Тэмцээнд 6 сумын 8 клубын 126 өсвөрийн шатарчид өрсөлдсөнөөс 40 гаруй хүүхэд багачууд авьяас чадвар, онц нүүдэл, оюун ухаанаа уралдуулан медаль болон шагналт байранд шалгарлаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсаар 01 дүгээр байдлаар 12 дуудлага бүртгэгдсэн ба орон нутгаар нь ангилахад ХЭУБ 1, Сүхбаатар 5, Мандал 3, Хушаат 2, Зүүнбүрэн 1 сумдад тус тус бүртгэгдэж, дуудлага мэдээллийг хамтарсан багуудад шилжүүлэн мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллалаа.

“Хүүхдэд ээлтэй Монгол” үндэсний чуулганы зөвлөмжийн хүрээнд орон нутгуудын “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн өргөтгөсөн хурлыг Мандал, Баянгол, Хушаат, Баруун бүрэн, Орхон, Сант, Сайхан, Орхонтуул сумдад батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж 120 гаруй албан тушаалтнууд оролцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2 удаа хуралдаж нийт 41 хүүхдийн асуудлыг шийдвэрлэлээ.

Сэлэнгэ аймгийн Сум дундын иргэний хэргийн Анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу 2 гэр бүл буюу 4 том хүн, 4 хүүхдэд шинжээчийн багийн дүгнэлт гаргасан. Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр 2 хүүхдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, сэтгэл зүйн тест авсан.

Шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлтийг 1 өрхийн 2 насанд хүрэгч, 3 хүүхдээс “шүүхийн журмаар гэр бүл цуцлахад хүүхдийн асран хамгаалагч тогтоох нэгдсэн арга зүйн гарын авлага” сэтгэл зүйн 14 багц оношилгооны тестийг авч, нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

Сэлэнгэ аймгийн Зооноз өвчин судлалын төвийн 20 ажилтан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 30 албан хаагч, Мандал суман дах 433-р хаалттай хорих ангийн 218 хүмүүжигч, 50 албан хаагч, Нэгдсэн эмнэлгийн удирдлагын багийн 20 ажилтанд “Эерэг сэтгэлгээ” сэдвээр сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, 338 албан хаагчийг хамрууллаа.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: 2023 онд тариалах үр тариа, тэжээл, тосны ургамал, төмс, хүнсний ногоо, уриншийн төлөвлөгөөг нэгтгэж, 2023 онд 125004 га талбайгаас 158404 тн үр тариа тн, 4548,96 га талбайгаас 26077,5 тн, 31516,7 га талбайгаас 12546,7 тн тосны ургамал, 1364 га талбайгаас 13522,7 тн төмс, 1784,05 га талбайгаас 19400 тн хүнсний ногоо, 114 га талбайгаас 74,4 тн жимс жимсгэнэ хураан авахаар төлөвлөсөн байна.

Газар тариалангийн салбарын улсын аварга 16, аймгийн аварга 27 материалыг хүлээн авч нэгтгэн 11 улсын аваргын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлэн, аймгийн аваргын материалын нэгтгэлийг хийсэн.

2022 оны улсын аварга малчин, фермерт ирүүлсэн нийт 11 материалд журмын дагуу шалгаруулалт хийж, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан хэлэлцэж ажлын үзүүлэлтээр тэргүүлсэн 4 малчин, 1 фермер, 1 саальчныг тодорхойлж Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд материалуудыг хүргүүлэн ажилласан.

Монголын Үндэсний радио телевизийн нэрэмжит “Алтан төлийн эзэн” шагналд нийт 10 материал ирснээс “Алтан тугал” 3, “Алтан хурга” 3 нийт 6 материалыг хүргүүлж ажиллалаа.

“Улсын залуу аварга тогооч-2023” уралдаанд “Галын бурхан тогоочид” ТББ тогоочдын холбооны тэргүүн Д.Аззаяа, Сүхбаатар сумын МСҮТ-ийн оюутан Ч.Анужин, Ө.Цолмонбаяр, Б.Ууганцэцэг нарын оролцож, оюутнууд ганцаарчилсан хар хайрцаг, багийн хар хайрцаг, орон нутгийн онцлогтой хоолны үзэсгэлэн төрөлд тус тус өрсөлдөн орон нутгийн онцлогтой хоолны үзэсгэлэнд “Мөнгөн медаль” хүртсэн.

Улаанбаатар хотод үндэсний уламжлалт сар шинийн баярыг угтан үйлдвэрлэл, үйлчилгээг орон даяар сурталчлах зорилгоор “Амар байна уу” үзэсгэлэн худалдааг “Шинэ зуун айл” худалдааны төвд зохион байгуулж, 6 сумын 14 иргэд, хоршоод цагаан идээ, зөгийн бал, варень, жимсний шүүс, даршилсан ногоо, төмс, хүнсний ногоо, эмийн ургамлын цай, зохицуулах үйлчилгээтэй хүнс, суран эдлэл, нум, сум зэрэг бүтээгдэхүүнээр оролцож байна.

“Монгол орны нөхцөлд дасан зохицсон FTMR тэжээлийн технологи ашиглан үхрийн ашиг шимийг сайжруулах загвар төсөл”-ийг хэрэгжүүлэхээр БНСУ-ын “Копиа Монгол” төвийн төслийн баг, Сант сумын 20 малчин өрхийг сонгон авч Монгол оронд тохиромжтой ферментжүүлсэн багсармал тэжээл үйлдвэрлэлийг нутагшуулахаар уг төслийг хэрэгжүүлж байна. Энэ төсөл нь ХААИС-тай хамтран зорилтот сумын малчин өрхүүдэд “Өвлийн улиралд өсвөр үхэр нэмэгдэл тэжээлтэй онд оруулах махны үхэр бордох” чиглэлээр 5 үхэр бордож онд оруулж, бэлчээрээр онд оруулсан малтай харьцуулж үр дүнг тооцох аргачлалыг практикт турших сургалт зохион байгуулж уг малыг бордох 1,5 тн буюу 3 урлон ногоон тэжээл, даршийг 20 өрхөд өгч дэмжлэг үзүүлж ажилласан.

Мал эмнэлгийн чиглэлээр: Малын эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, халдварт, зооноз, шимэгчтэх, халдваргүй өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх зорилгоор шинж тэмдэгт суурилсан эрт илрүүлгийн тандалт судалгааг 17 сумын Мал эмнэлгийн тасгаас зохион байгуулж, нийт 678 малчин өрх оролцож үзлэг шинжилгээнд 46.8 мянган толгой мал хамрууллаа.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 450 кг адууны махны 5 дээж, 6840 кг үхрийн махны 41 дээж, 2079 кг хонины махны 99 дээж, 320 кг ямааны махны 19 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 360 литр сүү, ааруул, тараг, цөцгийнний 14 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Сүхбаатар сумын 2 иргэний махан бүтээгдэхүүний 2 дээжийн 560 кг бүтээгдэхүүнд ариун цэврийн нян судлалын шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Харилцагч, үйлчлүүлэгчдээс ирсэн 178 сорьц дээжийг vetlab.shinjilgee.mn цахим сүлжээнд оруулсан.

Бог малын мялзан өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтыг 17 сумын тархвар зүйч нар зохион байгуулж 527 малчин өрх хамрагдсан.

Бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, анхааруулгыг 17 сумын мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр 3 удаагийн давтамжтай хүргүүлсэн. Аймгийн телевизээр улсын хэмжээнд гоц халдварт өвчний гаралт, тархалтын мэдээлэл, малчид, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн анхаарах асуудлаар 1 удаа ярилцлага өгсөн.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулах 8400 га талбайн, ойн зурвас байгуулах 614 га талбай, бургасжуулах 30 мянган га талбайн зургийг бүрэн гарган байршлыг тулган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахаар ажиллаж байна.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, тогтоомжийн сургалт”-ыг 17 сум, 6 тосгоны байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумдын Засаг дарга, Төрийн сангийн мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр: “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”, “14 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах зөвлөх үйлчилгээг “Вектор мэд” ХХК, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, экосистемийн тогтвортой байдлыг хангах” STREAM төслөөс “Ерөө, Жавхлант, Мандал сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг “Ланд овнер” ХХК хийхээр гэрээ байгуулж, 10 сумын төлөвлөгөөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 7 сумын төлөвлөгөөг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, санал авах шатанд үргэлжилж байна.

“Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, “Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, “Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-үүдэд санал авах хэлэлцүүлэг зохион байгуулж, 586 төрийн албан хаагч, 185 иргэнд мэдээлэл өгч, интэрнет хөтчөөр болон саналын хайрцгаар саналыг авч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 2023 оны газрын албан татвар ногдуулалтыг 29787 нэгж талбарт үүсгэхээс 11 сумын 14560 нэгж талбарт ногдуулалт, 12330 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Хүүхэд харах өрөөний засварын ажил”, Сүхбаатар сумын 15, 16, 17-р байрнуудын дээврийн засвар”, 6-р сургуулийн “Спорт заалны барилгын дээврийн засварын ажил”-ын барилгын зураг төсөв хянасан.

Хот байгуулалтын кадастрын Урбан менежер цахим мэдээллийн санд 17 сум, 6 тосгоны нийт 1492 барилга байгууламжийг бүртгэсэн.

Хот байгуулалтын кадастрын Урбан менежер цахим системд авто зогсоол, автобусны зогсоол, төмөр замын өртөө, авто тээврийн төвийн мэдээллийг зурж, бүртгэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн бүх сумд, тосгодын автобусны зогсоол, төмөр замын өртөө, авто тээврийн төвийн зургийг зурж, системд оруулан бүртгэх ажил 70 хувьтай, Орхонтуул, Сант, Баруунбүрэн сумдын хөшөө, баримал, усан оргилуурын фото зургийг авч системд бүртгэсэн.

Засгийн газрын 2021 оны 213 тогтоол, “Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу Сүхбаатар суманд “Наадмын талбайн био жорлон барих”, Орхон суманд “Төрийн албан хаагчдын барилгыг

засварлах, сантехникийн болон дотор засал”, 2-р багт “Үүрэн холбооны станц барих” ажилд тус тус барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон.

Засгийн газрын 2021 оны 212 тогтоол Барилга байгууламжийг ашиглалтад хүлээлцүүлэх дүрмийн дагуу Алтанбулаг суманд “Нэг бүс, нэг зам, нэг зорилго чөлөөт бүс” ХХК-ий захиалгаар “Бэлконстракшн” ХХК-ий гүйцэтгэсэн худалдаа үйлчилгээний барилга, Орхонтуул суманд “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ий захиалгаар “Мянган өндөр цахир” ХХК-ий гүйцэтгэсэн 25м өндөр холбооны цамхаг барих ажлууд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: 17 сумын 2023 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Сангийн яаманд хүргүүлэн батлуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг дарга болон Сангийн яамаар батлуулан цахим системд байршуулан олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэн ажилласан.

“Зууны мэдээ сонин”-ы 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн № 246 (6978) тоот дугаарт 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлүүлсэн.

Захиалагчаас 12 үнэлгээний хороо байгуулж, 3 зураг төсөв ирүүлсэн ажлын урилгыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлж зарлаж, “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-т насос худалдан авах, Аймгийн нэгдсэн музейн дээврийн засварын ажил, нийтийн эзэмшлийн байруудын дээврийн засвар /Сүхбаатар, Цэнхэр 15-17 байр/ ажлуудыг 2 дугаар сарын 27-ны өдөр нээлт хийхээр ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/03 тоот тушаалаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбогдон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг хүлээлцэх ажлын хэсгийг байгуулан үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг тус тус нүд үзэн тоолж баримтжуулах ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тайлант сард 1 удаа зохион байгуулагдаж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн. Үүнд:

1. Сумын газар зохион байгуулалтын 2022 оны зохин байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
2. 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах тухай
3. Мал амьтны шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө батлах тухай
4. Түлээний модны хуваарь батлах тухай, Бодлогын хороодын төлөвлөгөө батлах тухай
5. Сумын 2023 оны төсвийн тодотголд өөрчлөлт оруулах тухай

“Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” захирамжийн дагуу сумын төр төсвийн байгууллагын дунд Монгол Улсын Үндсэн хуулийг тайлбарлан таниулах сургалтыг зохион байгууллаа.

Хилийн 0243 дугаар анги, Цөх 3 дугаар багийн Засаг дарга, 7 малчин өрхтэй 332 бод малыг хилийн торон хашаанд хариулгатай бэлчээрлэх гурвалсан гэрээг байгууллаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 500 ширхэг боодол нөөцийн өвс хүлээн авсан. Иргэн Мөнхбадрахтай 1000 боодол өвсийг багийн Засаг даргын тодорхойлолтоор иргэнд 5000 төгрөгөөр худалдаалахаар гэрээ хийж ажиллаж байна.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 664 малтай өрх тоологдож үүнээс малчин өрх 534, мал бүхий өрх 127, тавиул малтай өрх 3 мөн аж ахуйн нэгж 6 тоологдсон байна. Нийт 201071 толгой мал буюу тэмээ 33, адуу 12660, үхэр 21148, хонь 104670, ямаа 62560 толгой мал тоологдож өмнөх онтой харьцуулахад тэмээ 3, адуу 1033, үхэр 1315, хонь 900 толгойгоор өсөж ямаа 2269 толгойгоор буурсан байна.

Сумын 2023 оны тариалалтын төлөвлөгөө болон шаардагдах үр, нөөцөлсөн үр, дутагдах үрийн судалгааг гаргаж аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлээ. Сумын хэмжээнд 11270 га талбайд улаанбуудай тариалах төлөвлөгөөтэй байгаагаас нөөцөлсөн улаан буудайн үр 1331 тн, дутагдсан үр 1011 тн, илүү нөөцөлсөн 396 тн байна.

Тус сумаас шалгарсан 2022 оны аваргуудын материалыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэн ажиллалаа. Үүнд “Улсын Аварга малчин”-аар Бургалтай 2 дугаар багийн малчин М.Элдэв-очир, “Аймгийн Аварга малчин”-аар Бургалтай 2 дугаар багийн малчин Б.Лувсанхүү, “Аймгийн Аварга фермер”-ээр Бургалтай 2 дугаар багийн малчин С.Батхуяг, “Алтан хурганы эзэн”-ээр Ивэнгийн 1 дүгээр багийн малчин Ц.Буянт, “Алтан унаганы эзэн”-ээр Ивэнгийн 1 дүгээр багийн малчин Б.Гансүх, “Аймгийн аварга тариаланч хамт олон”-оор “Бүрэн-эрдэнэ монос” ХХК шалгарсан.

Сумын Мал эмнэлгийн тасгаас “Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх эрүүлжүүлэх ариутгал халдваргүйжүүлэлт”-ийн төлөвлөгөөг боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж ажиллалаа.

Сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч М.Марина Улаанбаатар хотын “Шастины Улсын III дугаар төв эмнэлэг”-т яаралтай тусламж, сэргээн засах, дотор тасгуудад туршлага судалж ажиллалаа.

Баянгол сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар сумын 2023 оны төсвийг хэлэлцүүлэн батлуулж, Засаг даргын 2022 оны А/346 тоот захирамжаар төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг батлуулж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2023 оны А/01 тоот “Золбин нохой, муур устгах” тухай захирамжийн хүрээнд Хараа, Баян, Гонир багийн хэмжээнд нохой устгалын ажлыг зохион байгуулж нийт 134 нохой устгаад байна.

Боловсролын шинэчлэл нөхөн хангалтын төсвөөр багш, сурагчдыг цахим орчинд ажиллах, суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэн 2 зөөврийн компьютер, 45 таблеттай цахим танхимыг байгууллаа.

“Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо” эцэг эхийн чуулганыг зохион байгуулж, сумын удирдлагууд болон Монголын гэр бүл судлаачдын мэргэжлийн

холбооны тэргүүн гэр бүл судлаач Ж.Баясгалан, сургуулийн 35 бүлгийн эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл урилгаар ирж оролцлоо.

Мандал сум дахь Сум дундын прокурорын хэлтэс болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсээс нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, төр төсвийн байгууллагын 150 ажилтан албан хаагч хамрагдлаа.

2023 онд сумын орон нутгийн орлого нийт 1,352.0 сая төгрөгөөр батлагдсан. ОНХС-ийн хөрөнгөөр 1,032.2 сая төгрөгийн 10 ажил хийхээр төлөвлөсөн.

2023 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2.070.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд энэ онд 448.750.600 төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна. Мөн сумын ОНХС-ийн 726.239.500 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 ажил, арга хэмжээг, малын тоо толгойн албан татварын 306.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газрын “Хяналтын камер засвар, суурилуулалт”-ын 2.365.000 төгрөгийн ажлыг “Бүрэн цэнгэл” ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.

Сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимын тоног төхөөрөмж ашиглалтын хугацаа дууссан тул шинээр 2.119.000 төгрөгийн өртөг бүхий EPSON маркийн проектор авч суурилуулах, дэлгэцийг засварлах, компьютерыг шинэчлэх зэргээр сургалт, онлайн хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүллээ.

Засгийн газрын 2023 оны 11 тоот тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ын дагуу хүүхдийн мөнгө авах эрх үүссэн 1856 хүүхдэд 185600.0 мянган төгрөгийг олгосон.

Ерөө сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны А/02 дугаартай “Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” захирамжийг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 25 аж ахуй нэгж, иргэнд хүргүүлж, шаардлага хангасан 1 хүнсний дэлгүүрт Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгосон.

Сумын хэмжээнд урьдчилсан байдлаар 2023 онд 15 аж ахуй нэгж, 7 иргэн 12767 га талбайд үр тариа тариалахаар төлөвлөж, шаардагдах улаан буудайн үрийн нөөцийн судалгааг гарган холбогдох газарт хүргүүлж ажиллалаа.

Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй “Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдаанд “Бугант эх” хоршоог оролцууллаа.

“Дэлхийн зөн Монгол” ОУБ-тай хамтран “Сайн аав”, “Өсвөр насны хүүхдүүд” сургалтыг зохион байгуулж 30 аав, Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 45 хүүхдийг хамрууллаа.

Сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр удирдамжийн хүрээнд Ерөөгийн халуун рашаан орчимд ойн дагалт баялгийн нөөц ашиглах, бусад хуулиудын хүрээнд иргэдийн болон аж ахуй нэгжийн түлээ болон хэрэглээний модны эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж, самар түүж бэлтгэх 4 аж ахуйн нэгж, 56 иргэн жолоочид хуулийн зөвлөгөө өгч, зөвлөн тусалж ажиллалаа.

Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдсан “Аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөг”-ийн тэмцээн зохион байгуулагдаж 10 сумын 17 баг тамирчид оролцлоо.

Жавхлант сум:

Сумын Засаг дарга хөдөөгийн багийн айл өрхөөр ажиллаж, малчдын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцан, 2021-2022 оны Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн сэтгүүлийг хүргэж, иргэдийн санал хүсэлтийг сонслоо.

Уг ажлын хүрээнд цаг үеийн ажлын талаарх мэдээлэл хүргэн, сумын газар нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг иргэдэд танилцуулж хэлэлцүүлэг явууллаа. Тус хуралд сумын төв, хөдөөгийн багийн 200 гаруй иргэд оролцлоо.

Сумын Засаг даргын 2023 оны “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэх тухай” А/04 тоот захирамжаар Монгол улсын Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон холбогдох хууль, дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хүнсний аюулгүй байдал, эрүүл аж төрөх, хоол, хүнсээр дамжих хордлого, халдвар, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, үнийн харьцуулалт хийх, ажил үйлчилгээний чанар, стандартын шаардлыг хангуулах, согтууруулах ундаа худалдан борлуулж байгаа эсэх, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор 1 дүгээр цэцэрлэг, эрүүл мэндийн төв, хүнсний худалдаа үйлчилгээ явуулж байгаа 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийлээ.

Сумын Засаг даргын 2023 оны “2023 оны төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай” А/01 дүгээр захирамжаар төсвийн сар, улирлын хуваарь батлагдлаа. Үүнд:

- Сумын төсвийн орлого-1,580,716,300 төгрөг
- Сумын төсвийн байгууллагуудын зарлага-1,580,716,300 төгрөг

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2023 онд орон нутгийн төсвөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулсан.

| № | Худалдан авах, бараа ажил үйлчилгээ | Төсөвт өртөг /мян. төгрөг/ |
|-------------|--|-----------------------------------|
| 1 | Зураг төсөв хийх зардал | 3914,8 |
| 2 | Улсын байр наадмын зардал | 15000,0 |
| 3 | Хашаа хөтөлбөр | 20000,0 |
| 4 | ЗДТГ-ын урсгал засвар, техник хэрэгсэл | 20000,0 |
| 5 | Соёлын төвийн урлагийн хувцас нэмэгдүүлэх | 10000,0 |
| 6 | Сумын төвийн тохижилт сайжруулах | 20000,0 |
| 7 | Ахуй үйлчилгээний барилга худалдан авах | 90000,0 |
| Нийт | | 178914,8 |

Зүүнбүрэн сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар сумын газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний биелэлт, 2023 оны төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын тайлан, Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг шинэчлэх асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хоршоо хөгжүүлэх сангаас зээл сонирхож буй суманд үйл ажиллагаа явуулдаг баялаг бүтээгч 1 аж 18 иргэнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Хөгжлийн шийдэл” ТББ хамтран сургалт зохион байгууллаа.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд төрийн үйлчилгээг орон нутагт 2023 онд гэрээлэн гүйцэтгэх “Энхбүрэн сүрэг”, “Оюут сүрэг” Мал эмнэлгийн үржлийн нэгжүүдийн гэрээг шинэчлэн сумын хэмжээнд 560 өрхийн адуу 5025, үхэр 15700, хонь 35799, ямаа 31248 нийт 87952 толгой малд хамруулахаар шийдвэрлэлээ.

Мандал сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийн хэрэгжилтийг ханган 01 дүгээр сарын 04-20-ны өдрүүдэд зохион байгуулж, 95 хувийн хамралттай байна.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Б.Энхболд хяналт шалгалт, зөвлөн туслах чиглэлээр орон нутагт ажиллаж мөнгөн торгууль оногдуулсан цэргийн насны 50 гаруй залуус, түүний гэр бүлийн гишүүддээ уулзаж торгуулаа төлөхийг үүрэг болгож, цэргийн бүртгэл, мөнгөн торгуультай холбоотой мэдээллийг сумын иргэдэд видео хэлбэрээр өгч ажиллалаа. Батлан хамгаалахын хууль тогтоомжийг байгууллагын албан ёсны цахим хаягаар сурталчилж ажилласан ба 3200 иргэний хандалт авсан.

Сум орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулсан 15 салбарын 42 ажилтан, албан хаагчид төрийн дээд одон медалиар шагнагдсаныг гардууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 233 дугаар зарлигаар Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн бүлгийн багш Д.Оюумаа “Алтан гадас одон”-оор шагнагдлаа.

Сумын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон” аяныг өрнүүлж төр, төсвийн болон төрийн бус 40 аж ахуй нэгж оролцож 42 ажил, арга хэмжээг зохион байгуулж гэмт хэрэг зөрчилгүй нийгмийг бүтээхэд идэвхтэй оролцлоо. Шагналт байранд шалгарсан 4 аж ахуй нэгж байгууллагад 3.300.000 төгрөгийн шагнал гардууллаа.

Монгол Улсад шинэ ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тохиолдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ЗДТГ хамтран “АХА” тэмцээнийг зохион байгуулан 50 албан хаагчдыг хамруулж шагналт байранд шалгарсан Ж.Алтанчимэг, Э.Итгэлмаа нарыг шагнаж урамшууллаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, 1,6 дугаар багийн иргэдийн Нийтийн Хурлын төлөөлөгч, багийн Засаг нар хамтран “Буян дагуулсан буурлууд минь дээшээ суу” өдөрлөгийг зохион байгууллаа. Уг өдөрлөгт 1,6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Цогт Манлай” ХХК, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, “Азийн нахиа” эмийн сан, УБТЗ-ын харьяа БАҮ-ий 1 дүгээр анги, “Хандгай нуур” ХХК, “Видовүүд” ХХК, “Буянт царам” ХХК, “Тайгын нарс” ХХК хамтран дэмжлэг үзүүлж ажиллалаа. Азын сугалаанд нийт 37 азтанд 10 төрлийн хонжворыг гардуулан 370 ахмадыг баярлууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар “Бороо гоулд” ХХК-тай хамтран 2022 ондоо өөрийгөө тасралтгүй хөгжүүлэн, үе тэнгийн сурагчдаа зөвд үлгэрлэн манлайлж, эерэг бүхнийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулсан сургууль, сургуулийн төлөөлөл болсон 66 сурагчдыг урамшуулан “Оюун ухааны академи”-д 14 хоног үнэ төлбөргүй суралцах эрхийн бичиг, Hipposcards-англи хэл сурах 6 сарын эрх, шинэ жилийн баярын бэлэг гардууллаа.

Хэрх тосгон Зүүнхараа сангийн аж ахуй үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан шагайн харвааг хөгжүүлэх, сурталчлах, шагайн харваан уламжлал ёс жаягийг залуу хойч үедээ өвлүүлэх, харваачдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Шагайн харвааны бүсийн тэмцээ”-ийг зохион байгуулж 11 багийн 77 тамирчид оролцож цэц мэргэнээ сорилоо. Мөн Хэрх Ерөнхий боловсролын сургуулийн үеийн төгсөгчдийн дунд Гар бөмбөгийн тэмцээнийг 2 насны ангиллаар зохион байгуулж 31 багийн 217 тамирчид оролцлоо.

Сумын нутаг дэвсгэрт цас их орж, автозамын халтиргаа, гулгаа ихэссэнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны “Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах” тухай А/460 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган 65 аж ахуй нэгж байгууллагууд ойр орчмынхоо 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн 12.5 км талбай авто болон явган хүний замын цасыг 70 хувийн гүйцэтгэлтэй цэвэрлэлээ. “Тохилог хараа” ОНӨААТҮГ, “СББ”ХК-тай хамтран Ажнайн даваа, замын өндөрлөг хэсэгт 16 тн давс асгасан.

Сумын Засаг даргын 2022 оны “Мод бэлтгэх гэрээг сунгах тухай” А/462 тоот захирамжаар мод бэлтгэх хугацааг 2023 оны 01 дүгээр сарын 02-15-ны өдрийг хүртэл 14 хоногоор сунгаж, 6 аж ахуй нэгж байгууллага 877,62 м3 хэрэглээ, 201,1 м3 түлээ, 3 нөхөрлөл, 5 аж ахуй нэгж байгууллагын ойн сангаас 41 иргэнд 295 м3 түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг тус тус олгож 10,3 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

УБТЗ-ын Мод боловсруулах үйлдвэрт 135 м3 дэр мод, 56 м3 хагалсан түлээ, 10 аж ахуй нэгж байгууллагын 423 м3 хэрэглээ, 43 м3 түлээний модонд тус тус гарал үүслийн гэрчилгээг олгосон.

Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийлгэх 6 аж ахуй нэгж байгууллага хүсэлт гаргасны дагуу үйлдвэрлэлийн огтлолтоор 16 га, цэвэрлэгээний огтлолтоор 38 га 6 цэгт 54 га талбайд, “Хан Хэнтий” улсын Тусгай хамгаалалттай газарт 8 хүсэлт ирснээс 7 аж ахуйн нэгж байгууллагад цэвэрлэгээний огтлолтоор 160 га талбайд талбай тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хуш модны самар бэлтгэх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагуудын “Хуш модны самар бэлтгэх гэрээ”-ний хугацааг сунгаж 10 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулсан. Мөн 4 аж ахуйн нэгж байгууллагад 170 тн ойн дагалт баялаг ашиглах эрхийн бичиг, 7 аж ахуйн нэгж байгууллагад 200 тн самар тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээ олголоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “2023 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай” 86 тоот тогтоолоор Мандал суманд хэрэглээний 19976,6 м3, түлээний 13711,4 м3 нийт 33688 м3 мод хуваарилагдсан.

Сумын хэмжээнд сүүний мөнгөн урамшууллын гарал үүслийг 310 өрхөд 288000 литр сүүнд олголоо.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 77 дугаар тогтоолын дагуу 10 иргэн, 1 аж ахуй нэгжид Хоршоо хөгжүүлэх сангаас 230 сая төгрөгийн зээл олголоо.

Орхон сүм:

Монгол Улсад ардчилсан шинэ үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойн хүрээнд анхдугаар Үндсэн хуулиа батлалцсан Монгол Улсын гавьяат эдийн засагч А.Амжаа агсны нэрэмжит “Орхон бүс”-ийн аварга шалгаруулах “Гар бөмбөг”-ийн тэмцээн зохион байгуулагдаж эрэгтэй 16, эмэгтэй 7 баг оролцлоо.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах тухай” А/03 тоот захирамжийн дагуу цэргийн тоо бүртгэлийг 85 хувийн гүйцэтгэлтэй зохион байгууллаа.

Тус сумын Орхон, Бэлэндалай багийн иргэдийн Нийтийн Хурлыг зохион байгуулж 177 иргэн оролцлоо. Хурлаар сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, багийн Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны тайлан, өвөлжилтийн бэлтгэл, цаг үеийн мэдээлэл зэрэг 6 чиглэлээр мэдээлэл, таниулга хийгдлээ.

Улаанбаатар хот дахь “АМОС” ТББ-тай хамтран “Нийгмийн эрүүл мэнд ба гэр бүлийн эрүүл мэнд” сэдвээр сургалт зохион байгуулж, 52 иргэнийг хамрууллаа. Сургалтад оролцсон иргэдийн “Гадар, дотор өөхлөлт, булчингийн масс, бодисын солилцооны чадамж, эрүүл мэндийн насжилт, биеийн жингийн индекс” зэргийг тусгай аппаратын тусламжтайгаар үнэ төлбөргүй тодорхойлж өгсөн байна.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас “Хүүхэд ивээн тэтгэх түншлэл, суурь ойлголт”, “Хүүхэд хамгаалал, хүүхдийн оролцоо ба нөлөөллийн хөтөлбөр”-ийн хүрээнд “Гэрээр айлчлагч” сургалтад 2 албан хаагч хамрагдлаа.

“Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрт хамрагдсан өрхүүдээс “Цагаан идээ боловсруулах” сургалтыг Улаанбаатар хотын “Футур” сургалтын төв, Дэлхийн Зөн ОУБ, Сэлэнгэ ОНХХ-тэй хамтран зохион байгуулж, сургалтад Сант сумын 8 иргэн, Орхон сумын 7 иргэн нийт 15 иргэнийг хамруулж, чадамжийн гэрчилгээ олголоо. Сургалтад хамрагдсан иргэд сүүгээр 40 төрлийн бүтээгдэхүүн хийж боловсруулан үзэсгэлэн гаргалаа. Тус хөтөлбөрт хамрагдсан 15 өрхөд “Гэр бүлийн баяр хөөр” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

2022 оны жилийн эцсийн байдлаар сумын хэмжээнд мал бүхий өрх 191, малчин өрх 225 нийт 416 өрхийн адуу 6905, үхэр 15698, хонь 51095, 41942 нийт 115640 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 4.9 хувиар, малын төрлөөр адуу 6.4, үхэр 7.8, хонь 4.4, ямаа 4.3 хувиар тус тус өссөн байна.

Сүргийн бүтцээр авч үзвэл адуу 5, үхэр 12, хонь 46, ямаа 37 хувийг тус тус эзэлж байна.

2023 оны эхэнд сумын хэмжээнд байгаа малтай өрхийн “Малын бүлэглэлийн судалгаа”-г гаргахад 50 хүртэлх малтай өрх 111, 50-200 хүртэлх малтай өрх 133, 200-500 хүртэлх малтай өрх 86, 500-1000 хүртэлх малтай өрх 65 1000-1500 хүртэлх малтай өрх 17, 1500-2000 хүртэлх өрх 1 байна.

Орхонтуул сум:

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малчин, мал бүхий өрх бүрд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 3 аж ахуйн нэгжид гэрээний биелэлтийг хангуулах үүрэг даалгаврыг өгч тус суманд отроор өвөлжиж байгаа болон сумын 1,2-р багийн малчин өрхөөр өвөлжилтийн талаар болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор 2 удаа явлаа.

Мөн өвөлжилт хүндэрсэн 1, 2-р багийн малчин өрхүүдэд сумын нөөц өвсний бондоос 1400 боодол өвсийг хямдралтай үнээр олгон ажиллалаа. Шар-Ус 1-р баг Рашаант тосгоны иргэдтэй мал аж ахуйн талаар зөвлөлт уулзалтыг 1 удаа зохион байгууллаа.

Тус сумтай залгаа Төв аймгийн Баян чандмань суманд хонины цэцэг өвчин гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын өгсөн чиглэлийн дагуу ажлыг зохион байгуулан хил залгаа малчин өрхүүдэд мэдээлэл хүргүүлэн ажиллалаа.

Сайхан сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” А/03 тоот захирамжийн хүрээнд сумын хэмжээнд 1 дүгээр сарын 04-20-ны өдрүүдэд зохион байгуулж, 18-50 насны нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн болон 65 хүртэлх насны бэлтгэл офицеруудыг хамруулан алба хаасан эрчүүдийг бүртгэж ажиллалаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай” 39 дүгээр тогтоолын дагуу “Сонгон шалгаруулах зөвлөл” 17 иргэний төсөлд сонгон шалгаруулалтад хийж 7 иргэний 105,000,000 төгрөгийг санхүүжүүлэх шийдвэр гарган ажиллалаа.

“Гал түймэртэй тэмцэх байгууллага үүсэж хөгжсөний 101 жилийн ой”-д зориулан Сайхан сумын өсвөр үеийн зуун буудалт даамны аварга шалгаруулах тэмцээнийг Гал түймэр унтраах, аврах 61-р ангитай хамтран зохион байгууллаа. Мөн Гал түймэр унтраах, аврах 61-р ангийн албан хаагчдыг сумын Засаг даргын “Жуух бичиг”, “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнаж урамшууллаа.

Засгийн газрын 2022 оны “Мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолын дагуу тус суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 3 иргэн, 18 аж ахуйн нэгж 768 сая төгрөгийн урамшуулалд хамрагдсан байна.

Сант сум:

Сумын удирдлагууд төсөвт байгууллагын үйл ажиллагаатай танилцан цаг үеийн болон тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар харилцан санал солилцлоо.

“Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хуулийн тухай мэдээлэл, Үндсэн хуулийн хөгжлийн түүхэн товчоон баримтат кино, хууль батлалцаж явсан депутат нарын түүх, намтрыг Santzdtg, Сант Соёлын төв, Ивэн голын хүүхдүүд цахим хаягаар сурталчилж нийт 391 хүний хандалт авсан Мөн Шатар, даам, АХА тэмцээнийг зохион байгуулж, тэмцээний аваргуудад өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Улаанбаатар хотод 01 дүгээр сарын 20-ноос 02 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж буй “Амар байна уу” үзэсгэлэн худалдаанд тус сумаас “Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоо” цагаан идээ, зөгийн бал, дарсан ногоо зэрэг төрлүүдээр оролцож байна.

Монгол Солонгосын хамтарсан “Копио Монгол” төслийн хүрээнд ХААИС-аас багш нар ирж төсөлд хамрагдсан 20 өрхөд “Эрдэс тэжээл”, “Монгол үхрийн тэжээлийн жорыг эрдсээр баяжуулах боломж”, “Малын тэжээлийн нэмэлт, ач холбогдол, ашиглалт” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

“ФУТУР” сургалтын төвөөс зохион байгуулсан “Сүү цагаан идээ боловсруулах” сургалтад сумаас “Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрт хамрагдаж байгаа 8 иргэнийг хамруулж чадамжийн гэрчилгээ олгосон. Сургалтын төлбөр 1.760,000 төгрөгийг “Дэлхийн Зөн Монгол” ОУБ “Сэлэнгэ нутгийн хөтөлбөр”-өөс санхүүжүүллээ.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ “Сэлэнгэ нутгийн хөтөлбөр”-ийн санхүүжилтээр УБ хот дахь GANABELL сургалтын төвөөс “Удирдах ажилтны манлайлал”, “Сайн аав” сэдвээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, сумын удирдлагууд, Засаг даргын Тамгын газрын 19 албан хаагч, 17 аав нийт 36 хүн хамрагдлаа.

Сумын Засаг даргын ивээл дор “Авьяаслаг Сантчууд” урлагийн наадмыг зохион байгуулж Ерөнхий боловсролын сургууль, 1-р цэцэрлэгийн хамт олны урлагийн тоглолт, цэнгүүн нийтийн хүртээл болголоо. Урлагийн тоглолт, цэнгүүнд 66 багш, ажилчид оролцож 175 иргэн үзэж сонирхлоо.

Сүхбаатар сүм:

Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар болон төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг үнэлэх хяналт шалгалтын бэлэн байдлыг хангуулах зорилгоор сумын Засаг даргын 2023 оны А/03 тоот захирамжаар ажлын хэсгийг байгуулан зөвлөн туслах ажлыг төлөвлөгөөний дагуу Ерөнхий боловсролын 7 сургууль, сургуулийн өмнөх 8 цэцэрлэг, “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ”, “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын ажлын зохион байгуулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ажил, нийгмийн бодлогын ажил үйлчилгээ, төсөв санхүүгийн ажил үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хог хаягдлын менежмент, өвөлжилтийн бэлтгэл ажил, 2022 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажилтай танилцаж, төр төсвийн байгууллагуудын төсвийн ил тод байдал, шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж хугацаатай үүрэг чиглэл өгсөн.

Бүгд Найрамдах Чех улсын “Каритас Чех Републик” байгууллагын Прага дахь төв албаны мэргэжилтэн Камиль Спиталс болон “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн хамт олныг сумын Засаг дарга хүлээн авч 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа танилцуулж, орон нутгийн залуучуудын хөгжил, тэдний нийгмийн оролцооны асуудлаар цаашид хамтран ажиллах тал дээр харилцан санал солилцож, тус сумын малчин өрх Б.Батсуурийн гэрээр зочлуулан Монгол ахуйтай танилцуулах аяллыг зохион байгууллаа.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-тай хамтран гэр бүлийн харилцаа болон хүүхдийн хүмүүжил төлөвшилд аавуудын идэвх оролцоо, хариуцлага, хүүхэд бүрийн сайн сайхны төлөө эерэг өөрчлөлтийг бий болгох, нийгэмд зөв үлгэрлэл үзүүлэх, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг нэмэгдүүлэх зорилгоор “Сайн аав, хичээнгүй хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд сургалтыг зохион байгуулж 8 багийн 320 аав хамрагдсан.

Аймгийн улаан загалмайн хороо, “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн соёлын төв” ТББ хамтран Сүхбаатар сумын сонсголын бэрхшээлтэй иргэдэд “Сонсголгүй иргэдийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хамтын ажиллагааны гарааг эхлүүлэх” уулзалт, сургалтыг зохион байгуулж 40 гаруй сонсголын бэрхшээлтэй иргэн хамрагдсан.

“Дэлхийн зөн Монгол” ОУБ-тай хамтран 8 багийн иргэдэд “Гэр бүлийн баяр хөөр” сэдэвт сургалтыг зохион байгуулж 40 гаруй иргэнийг хамруулсан.

Сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 8 багийн Засаг дарга, “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ”, “Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга нар сумын хэмжээний зам талбайн хог хаягдал болон асахгүй байгаа гэрэлтүүлгийн судалгааг гаргаж, уг асуудлыг шийдвэрлэх талаар чиглэлийг өгч ажиллалаа.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-тай хамтран “Цагаан-эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ тус сумын нийтийн эзэмшлийн зам талбай, автозамын цас, мөсийг хусаж хайрга, дайрга дэвсэж ажилласан байна.

Тус сумын 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө буюу 38 ажлыг tender.gov.mn оруулж сумын төсвийн ерөнхийлөн захирагч болон сангийн яамаар батлуулан ажиллалаа.

Түшиг сумын “Улаан овоо” уурхайд үйл ажиллагаа эрхэлдэг “Техно перспектив” ХХК-тай 1 өрхөд 2 тн нүүрс олгох гэрээ байгуулж 1 тонн нүүрсийг 88,200 төгрөгөөр худалдан авдаг байсныг 68,200 төгрөгөөр худалдан авах боломжийг бүрдүүлж ажиллалаа.

Мөн Сүхбаатар сумын хэмжээнд асран хамгаалагч харгалзан дэмжигчгүй, амьжиргааны түвшнөөс доогуур орлоготой ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон 4-өөс дээш хүүхэдтэй эцэг, эхийн сарын нүүрсний хэрэглээний судалгааг гаргаж 97 өрхийн 401 иргэнд 70 тн нүүрсний тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Төрөөс малчдад хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг танилцуулах, хууль зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах малчдын санал бодлыг сонсож орон нутагт хөдөө аж ахуй, мал аж ахуйн чиглэлээр баримтлах бодлого, төлөвлөлтийг оновчтой тодорхойлох зорилгоор тус сумын малчин, мал бүхий иргэдэд “Төрийн үйлчилгээг малчдад” өдөрлөгийг зохион байгуулж Хонгорморьт 1 дүгээр багийн “Овоо толгой”, Боргүвээ 5-р баг, Баянхан 4-р баг, Буурхээр 8-р багийн нийт 55 өрх хамрагдаж малчин, мал бүхий иргэдэд хивэг тэжээл болон бусад дэмжлэг тусламжийг үзүүлэн өвөлжилтийн байдалтай танилцаж тэдний санал хүсэлтийг сонсож ажиллалаа.

Арга хэмжээг аймгийн Онцгой байдлын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газар, Цагдаагийн газар, “Номт хан” ӨЭМТ, “Алтантариа” ХХК-ий Сэлэнгэ салбар хамтран зохион байгууллаа.

Малчин өрхийн амьжиргааг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын “Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөр”, “Футур” сургалтын төвтэй хамтран “Цагаан идээ боловсруулах” сургалтыг зохион байгуулж тус сумын 15 иргэн хамрагдаж сүү, сүүн бүтээгдэхүүнээр төрөл бүрийн эко амттан, хүнс хийх ур чадвар эзэмшиж, цаашид хоршоолол байгуулах санаачилга гаргаж сумын Засаг дарга дэмжин ажиллахаар боллоо. Мөн эко аргаар боловсруулсан бүтээгдэхүүний үзэсгэлэн гарган танилцууллаа.

Түшиг сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 67 дугаар тогтоолын дагуу Засаг даргын 2023 оны А/02 тоот захирамжаар “Сумын 2023 оны сар, улирлын хуваарь”-ийг баталлаа.

Сумын Засаг даргын 2023 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах тухай” А/03 дугаар захирамжаар төрийн байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу хариуцах албан хаагчдад үүрэг чиглэл өгч, хариуцах албан хаагчийг томилгоожуулж өгсөн.

Мөн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх үүднээс хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авах ажлын хэсгийг Засаг даргын 2023 оны А/04 тоот захирамжаар томиллоо.

Монгол Улсын Анхдугаар шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, төрийн албан хаагч, иргэдийн дунд 4 төрөлт спортын

арга хэмжээг зохион байгуулж, нийт 7 багийн 50 гаруй иргэд оролцлоо. Тэмцээний нийт дүнгээр:

- 1-р байранд Н.Энхриймаа эрхлэгчтэй Цэцэрлэгийн баг
- 2-р байранд Ч.Баттүшиг ахлагчтай ИТХ-ын баг
- 3-р байранд Н.Буянтогтох ахлагчтай ЕБС-ийн баг тамирчид шалгарлаа.

Сумын Засаг даргын 2023 оны А/01 дүгээр захирамжаар “Цэргийн шинэчилсэн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсэг”-ийг байгуулж, цэрэгт бүртгэлтэй 1, 2 дугаар цэргийн үүрэгтэн, идэрчүүд болон цэрэгт бүртгэлтэй эмэгтэйчүүдийг бүртгэж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Газрын багц хуулийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэх ажлыг төрийн албан хаагч, иргэдэд зохион байгуулж 37 иргэн оролцлоо.

2022 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нийт 56461 толгой буюу урьд оноос 2000 толгой 3,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Малын төрөл тус бүрээр ангилбал Адуу 3217, Үхэр 10885, Хонь 24265, Ямаа 16087 толгой тус тус тоологдлоо.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хяналт шалгалтын ажлын удирдамжийн хүрээнд “Улаан-Овоо”-ийн уурхайд олборлолт явуулж буй “Технопреспектив” ХХК-ий үйл ажиллагаанд хяналт шалгалтыг явуулж, илэрсэн зөрчил дутагдлын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт албан бичгийг хүргүүллээ.

2022 оны мод бэлтгэх хуваарийн дагуу УБТЗ-ын Мод боловсруулах үйлдвэрийн Хашаатын аманд бэлтгэсэн модонд хэмжилт хийж, тооллогын акт үйлдлээ.

Хушаат сум:

Шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хуулийн видео сургалт, Үндсэн хуулийг бүрэн эхээр нь сурталчлах, Халтарын Намсрайжав агсны талаар видео, зурган дурсамжийг сурталчлах зэрэг үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж нийт 1222 иргэн үзэж танилцлаа. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Х.Намсрайжав агсны үр хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Х.Намсрайжав агсны нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг Х.Намсрайжав агсны хүү Н.Батбаярын гэр бүл, ах, дүү, үр хүүхдүүд зохион байгуулж эрэгтэй 5, эмэгтэй 9 баг, нийт 14 баг тамирчид оролцлоо.

“Шинэ үеийн манлайлагч” төрийн албан хаагчдын 5-р зөвлөгөөнийг зохион байгуулж төр, төсвийн 5 байгууллагын удирдлагууд 2022 оны ололт амжилтаа дурдан Энхтал САА, Хушаат суманд 36 дахь жилдээ ажиллаж амьдарч байгаа Засаг даргын орлогч Ч.Ганзориг ахмад төрийн албан хаагчийн хувьд сургамж үгээ хэллээ.

Зөвлөгөөний үеэр аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 3, сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр 6 албан хаагч шагнууллаа.

“Цаг баримтлагч төрийн албан хаагч”-аар Соёлын төвийн үйлчлэгч Г.Батцэцэг, “Манлайлагч төрийн албан хаагч”-аар 1-р цэцэрлэгийн нярав Л.Солонго, “Бүтээлч төрийн албан хаагч”-аар Эрүүл мэндийн төвийн жолооч Т.Гэрэлтуяа, “Шинийг санаачлагч төрийн албан хаагч”-аар Ерөнхий боловсролын сургуулийн багш Э.Өлзийжаргал, “Ёс зүйтэй төрийн албан хаагч”-аар Нийгмийн даатгалын улсын байцаагч Г.Батцэцэг нарыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Монголын Залуучуудын Холбооны 100 жилийн ойн медалиар Ерөнхий боловсролын сургуулийн багш Л.Отгонбаяр, Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр эрхлэлт, халамж хариуцсан мэргэжилтэн М.Энхмаа, Ерөнхий боловсролын сургуулийн багш, Т.Энхтүвшин нарыг шагналаа. Арга хэмжээнд нийт 96 албан хаагч хамрагдсан.

Төрийн албан хаагчдын 5-р зөвлөгөөний хүрээнд төсвийн 5 байгууллагын дунд гар бөмбөг, сагсан бөмбөг 3х3, шатар, дартс, теннис, багийн даамны тэмцээнүүд зохион байгуулж шилдгүүдээ шалгарууллаа.

“Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн “Шинэ үеийн манлайлагч” төрийн албан хаагчдын 5-р зөвлөгөөний хүрээнд төрийн албан хаагчдыг ажлын байран дээр чадавхжуулах, төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг төлөвшүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран ажиллаж албан хаагчдад “Төрийн албан дахь манлайллын хэрэгцээ, манлайллын хэв маяг”, “Төрийн албан хаагчдын ёс зүй, ёс зүйн хоёрдмол байдал”, “Цахим хэрэглүүрийг ашиглан бүтээмжээ нэмэгдүүлэх нь” сургалтуудыг явуулж нийт 96 төрийн албан хаагч хамрагдлаа.

Эрүүл мэндийн газраас малчин өрх, ард иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн “Халуун сэтгэл” үзлэгийн багийг томилж Хушаат суманд ажиллалаа. 17 эмчээс бүрдсэн үзлэгийн баг Даагат, Мөнхтолгой багийн малчин өрхийн иргэдэд дотор, хүүхэд, эх барих, эхо, эмийн сан, явуулын амбулаторийн үйлчилгээ үзүүлж 100 гаруй өрхийн 154 иргэнд үзлэг оношилгоо хийж үйлчиллээ.

Суурин багт эмэгтэйчүүд, дотор, шүд, сэтгэцийн эмч нар үйлчилж нийт 245 иргэн үзлэг оношилгоонд хамрагдлаа.

Хүдэр сум:

Монгол Улсад Ардчилсан шинэ үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тохиолдуулан Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар хамтран Үндсэн хууль, Хүний эрхийн талаар сургалт сурталчилгааны ажлыг төр, төсвийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан зохион байгуулж, иргэдэд хуулийг сурталчилж ажиллалаа.

Тус сумаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын депутатаар сонгогдсон Г.Хашбаатарын түүхэн дурсамжийг иргэдэд сурталчлан Засаг даргын Тамгын газрын цахим хаягт байршуулан ажилласан.

БОАЖС-ын “Хуш модны самар түүж бэлтгэх тухай” 2022 оны А/372 дугаар тушаалаар Хүдэр сум үйлдвэрлэлийн зориулалтаар ойн дагалт баялгийг хамгаалах ашиглах эрх бүхий 24 аж ахуйн нэгж, ойн санг гэрээгээр эзэмшигч 3 аж ахуйн нэгж нийт 1590 тн самар түүж бэлтгэхээр гэрээ байгуулан ажилласан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын дагуу Хүдэр суманд хэрэглээний 17366 м3, түлээний 13714 м3 мод, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 23 аж ахуйн нэгж, 3 нөхөрлөл, 1,2-р багийн хэрэгцээнд хэрэглээний 11773 м3, түлээний 10467 м3 модыг тус тус хуваарилан баталсан байна. Үүний дагуу сумын Засаг даргын 2023 оны “Ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэх ажлыг зохион байгуулах тухай” А/05 дугаар захирамж гарч мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажил хийгдэж байна.

Цагааннуур сум:

Сумын Засаг даргын захирамжаар түүхий эд, хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор хадгалах хугацаа дууссан, буцаан татан авалт хийх, сав баглаа, боодол, хаяг шошгын зөрчилтэй нийт 273 нэр төрлийн 8.3 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүн илэрч зөрчлийг арилгуулж ажиллалаа.

Сумын төр, төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлагуудын хурлыг зохион байгуулж, хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар сонсож, санал солилцсон. Мөн 2022 оны жилийн эцсийн статистик тоо баримт, 2022 онд суманд хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, 2023 онд хийгдэх хөрөнгө оруулалтын зарим ажил арга хэмжээний талаар товч мэдээлэл өгсөн.

2023 оны спортын уралдаан тэмцээн, соёлын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу иргэдийн дунд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Спорт цогцолбор хамтран “Эрүүл агаар эм” цасны баярын арга хэмжээг зохион байгуулж, нийт 12 баг хөл бөмбөг, олс таталт, Сумо зэрэг уралдаант тэмцээнд өрсөлдсөн.

Сумын аварга шалгаруулах “Ахмадын волейбол”-ын тэмцээнийг Монгол Улсын Спортын мастер Б.Аюушийн нэрэмжит болгон зохион байгуулж, 11 баг тамирчин өрсөлдсөн.

Шаамар сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны А/03 тоот захирамжаар 2023 оны Цэргийн тоо бүртгэлийг сумын хэмжээнд зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт шинэчилсэн бүртгэлийн мэдээг хүлээлгэн өгөхөд бэлтгээд байна.

Сумын Засаг даргын захирамжаар “Иргэнээ сонсьё” аяныг өрнүүлж, арга хэмжээний хүрээнд сумын Засаг даргын орлогч ,1, 2, 3-р багийн Засаг дарга нар 7 хоногийн Лхагва гариг бүр өрхөөр зочлон тэмдэглэл хөтөлж Засаг даргад тайлагнан ажиллаж байна.

“Өрх бүрт хүлэмж” хөтөлбөрт хамрагдсан ногоочдыг АНУОУХ агентлагийн санхүүжилтээр “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй “BEST” хөтөлбөртэй хамтран хөгжүүлэх чадавхжуулах дадлага туршлага судлах чиглэлээр “Өсье өрсөлдье” хөтөлбөрийн дагуу ногоочдоо сургаж сургалтад хамруулсан.

ХХААЯ-ны “Хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл”-өөс 8 иргэнд хүлэмж олгосон.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА